Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх
зүйн хэлтсийн даргын 2026 оны ..01..дугаар
сарын ...12...-ны өдрийн ...3/10...дугаар
албан бичгийн хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООДЫН 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН

НЭГ. Товч танилцуулга

Аймгийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 194 төсвийн байгууллагын 6300 орчим төрийн албан хаагч ажиллаж байгаа ба эдгээрт Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор аймгийн хэмжээнд нийт 160 байгууллагын ёс зүйн дэд хороонд 480 төрийн албан хаагч гишүүнээр ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх дараах эрх зүйн баримт бичгүүдээр цахим сан үүсгэн төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулан мэдээллээр ханган ажиллаж байна. Үүнд:

- “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” *Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 27 дугаар тогтоолоор батлагдсан.*


- “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” *Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан.*

- “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” *Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” 109 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан.*

- “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам” *Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн “Журам батлах тухай” 13 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан.*

Аймгийн хэмжээний нийт төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын сахилга хариуцлага, зөрчлийн хэрэгт холбогдсон асуудалд хяналт-шинжилгээ хийх, гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор зөрчлийн хэрэг нээж шалган, шийдвэрлэгдсэн нийт төрийн албан хаагчдын судалгааг мэргэжлийн байгууллагаас гаргуулан дүн шинжилгээ хийж үзэх зэргээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсээр байна. Нийтийн албанд ажиллах эрх хасуулах ялаар шийтгүүлсэн этгээдийн судалгааг хөтөлж, Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтаар төрийн албанд ажиллаж байгаа эсэхийг хянаж ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой зөрчлийн талаарх мэдээллийг 2025 оны байдлаар авч үзвэл:




- Ёс зүйн зөрчил нь төрийн албаны ангилал болон зөрчлийн төрлөөр дараах байдалтай байна.





Ёс зүйн зөрчил гаргасан 11 албан хаагчид дараах шийтгэл ногдуулсан байна.



Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хууль тогтоомж, холбогдон гарч буй эрх зүйн баримт бичгүүдийг сурталчлах зорилгоор:

- "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хууль хэрэглээ"
- "Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд"
- "Төрийн албан хаагчийн ёс зүй гомдол, мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх"
- "Төрийн албан хаагчийн ёс зүй-дижитал ёс зүй"

- "Төрийн албан хаагчийн ёс зүй ба бодлого үйл ажиллагаа" сэдэвт сургалтуудыг аймгийн хэмжээний төрийн байгууллагуудын давхардсан тоогоор нийт 6300 орчим албан хаагчдад тодорхой давтамжтайгаар зохион байгуулж ажиллаж байна.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гуравдугаар бүлэг болох засаглалын бодлого хэсгийн зорилт нэг (Төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, давхардлыг арилгах, үйл ажиллагааны уялдааг хангах замаар үр ашигтай бүтэц бүхий мэргэшсэн чадварлаг, тогтвортой, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлнэ)-ийн хүрээнд

- "Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон дүгнэж, мэдээллийн санг бүрдүүлнэ",

- "Төрийн албаны сонгон шалгаруулалт, хүний нөөцийн томилгоо, сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой шийдвэрийг бүх байгууллагад ил тод, нээлттэй болгоно" гэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дөрөвдүгээр бүлэг (Төрийн бүтээмж-цахим засаглал)-ийн орон нутгийн хүний нөөцийн бодлого төлөвлөлт хэсгийн Чадахуйн зарчимд суурилсан ёс зүйтэй, мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний үр нөлөөг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг бууруулахыг зорин дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд:

-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг мөрдөх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

-Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэж, хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

-Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог чадавхжуулах, ёс зүйн дэд хорооны ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан тогтвортой ажиллах хөшүүрэг болох урамшууллыг олгоно.

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

Аймгийн хэмжээний бүх төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хорооноос хэрэгжүүлэх үйл ажиллагаа, зохион байгуулах сургалтын хөтөлбөр боловсруулан, төрийн албан хаагчдад **Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр", авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр энэ төрлийн гэмт хэрэг зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх** хууль, эрх зүйн сургалтуудыг зохион байгуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгон **сургалт, мэдээллийн үйл ажиллагааг давтамжтай зохион байгуулан ажиллаж байна.**

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг мөрдлөг болгон ажиллах, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороо байгууллага дээрээ албан хаагчдадаа ажиллаж байна.

Мөн төрийн байгууллагуудын Хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчид байгууллага дээрээ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг сурталчлах, сургалт зохион байгуулах ажлуудыг байнга давтамжтай зохион байгуулан ажиллах талаар зөвлөмж, дэмжлэг өгч ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчид удирдах болон гүйцэтгэх албан тушаалын нийт 80 орчим албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон авлига, авлигын эсрэг хууль тогтоомжийг чанд мөрдөн, ёс зүй, сахилга хариуцлагатай байж хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, аливаа хууль бус үйлдэлд автахгүй, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах тухай баталгааг гаргуулж ажилладаг ба харьяа байгууллагууддаа мөн мэдээлэл, зөвлөмж өгч ажиллав.

Ёс зүйн дэд хороод жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж төлөвлөгөөний дагуу байгууллагын албан ёсны веб хуудсанд ёс зүйн дэд хорооны цэс үүсгэн мэдээ мэдээлэл байршуулан ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, ёс зүйн дүрмийн сургалтыг явуулснаар байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хэрхэн хянан шийдвэрлэхтэй холбоотой мэдээлэл, төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтан хариуцсан салбар, байгууллага, нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавьж, төрийн албан хаагч Төрийн албаны тухай хууль болон энэ хууль дүрмээр хүлээсэн хэм хэмжээг хэрхэн сахин мөрдөж ажиллах тухай мэдлэг мэдээллийг өгч ажиллав.

Сумдад хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр сургалт, мэдээлэл өгч ажилласан байдал

Д/д	Сумын нэр	“ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хууль хэрэглээ”	“ Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл_мэнд”	“ Төрийн албан хаагчийн ёс зүй гомдол, мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх”	“ Төрийн албан хаагчийн ёс зүй-дижитал ёс зүй”	“ Төрийн албан хаагчийн ёс зүй ба бодлого үйл ажиллагаа”
1	Арвайхээр	810	698	154	269	195
2	Баруунбаян-Улаан	210	54	44	47	44
3	Бат-Өлзий	21	69	59	62	59
4	Баянгол	195	35	25	28	25
5	Баян-Өндөр	164	29	19	22	19
6	Богд	152	58	48	51	48
7	Бүрд	190	31	21	24	21
8	Гучин-Ус	170	49	19	42	39
9	Есөнзүйл	180	39	29	32	29
10	Зүүнбаян-Улаан	138	25	15	18	15
11	Нарийнтээл	120	26	16	19	16
12	Өлзийт	156	27	17	9	17
13	Сант	167	31	21	24	21
14	Тарагт	132	45	35	38	35
15	Төгрөг	198	25	15	18	15
16	Уянга	260	26	16	19	16
17	Хайрхандулаан	186	28	18	21	18
18	Хархорин	450	256	246	249	246
19	Хужирт	290	152	142	145	142

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт дүн шинжилгээ, хяналт үнэлгээ хийсэн багт аймгийн Ёс зүйн дэд хорооны дарга буюу ажлын хэсэгт орж ажилласан.

2.3. Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаа:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Ёс зүйн дэд хороо байгуулах тухай” А/05 дугаар тушаалаар аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд Ёс зүйн дэд хороог байгуулсан ба дэд хорооны дарга болон нарийн бичиг нарт тодорхой хэмжээний урамшуулал олгож ажилласан. Аймгийн засаг даргын Тамгын

газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь зөвхөн байгууллагын хүрээнд төдийгүй аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллага, сумдын удирдлагуудын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг хүлээж байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн "Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай" А/28 дугаар тушаалаар дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 3 дахь хэсгийн 3.8 дахь заалтын дагуу Дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улиралд нэг удаа урамшуулал олгох шийдвэр гарган ажиллаж байна.

Тухайлбал аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь 2025 оныг "Ёс зүйг эрхэмлэх" зорилтот жил болгон зарлаж, соёл, урлагийн салбарын төрийн албан хаагчийн ёс зүйн манлайллыг нэмэгдүүлэх, төрөөс соёл, урлагийн талаар баримталж буй бодлогын баримт бичгүүдийн зорилтыг хэрэгжүүлэх, ёс зүйтэй төрийн албыг соёлын салбарт төлөвшүүлэх зорилгоор Соёл бол гоёл арга хэмжээг зохион байгуулсан. Мөн "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Байгууллагын стресс менежмент" зэрэг сэдвээр танхимын сургалтыг зохион байгуулж, 130 гаруй ажилтан, албан хаагчдыг хамруулсан төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэн манлайлж ажиллав.

Татварын газраас ажлын орчин, гэр бүл, найз нөхдөө хүндэтгэх, эелдэг найрсаг харилцааг бий болгох, дэмжих, урамшуулах соёлыг ажил, хамтын орчиндоо төлөвшүүлэхэд чиглэсэн

- "Хүндэлье"-Тусалж дэмжих, өгөөмөр сэтгэлээр хүндэтгэх,
- "Энэрье" - Энэрэн хайрлах, өршөөх, ууч сэтгэлээр хандах бид хамтдаа ёс зүйн манлайллыг төлөвшүүлж, итгэл төрүүлэх төрийн үйлчилгээг бий болгохын төлөө ажиллана аянг зохион байгуулж ажилласан.

Арвайхээр сумын Ёс зүйн дэд хорооноос Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил ихсэж байгаатай холбогдуулан байгууллагын албан хаагчдыг тус зөрчлөөс урьдчилан сэргийлэх мөн харьяа нутаг дэвсгэртээ гарч байгаа зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар дараах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:

- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах зорилгоор Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагтай хамтран байгууллагын нийт алба хаагчдад сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.
- Нийт алба хаагчид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх уриалга дэвшүүлэн "Уусан бол бүү жолоод" аян өрнүүлж нийт 50 албан хаагч нэгдэн гарын үсэг зурж баталгаажуулан ажиллав.

Аймгийн Эрүүл мэндийн газраас эрүүл мэндийн салбарын хүрээнд "Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг дээшлүүлье" 3 сарын аянг зарласан ба аяны хүрээнд сумдууд хөөрхөн юмнууд хийсэн нийтлэгээр

ЭМТ-ийн эмч мэргэжилтнүүдэд 2 хоногийн хугацаанд сэтгэлийн илгээмжийн аяныг хэрэгжүүлсэн.

Гарсан үр дүн, ололт амжилт:

Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлалын дагуу үнэлгээний багийг байгууллагын даргын тушаалаар байгуулж, төрийн албан хаагчийн хандлага, ёс зүй, ур чадварт дүн шинжилгээ хийж ажилладаг ба шинийг санаачлах, хариуцлага хүлээх чадваруудыг хандлага, ёс зүй, ур чадварын

үнэлгээний хүснэгтээр, ажлын цаг ашиглалт, цагийн менежментийг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийн бүртгэлд үндэслэн тус тус үнэлэн ажиллаж байна. Монгол Улсын ёс зүйн хорооноос орон нутагт Ёс зүйн сургагч баш бэлтгэх сургалтад төрийн албан хаагчдыг бэлтгэсэн ба тус сургалтад Өвөрхангай аймгаас 2 төрийн албан хаагч хамрагдан дараах сэдвүүдээр орон нутагт сургалтуудаа амжилттай зохион байгуулж байна. 1. ёс зүйг дээдэлсэн байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд төрийн албан хаагчийн оролцоо 2. төрийн албан хаагчийн ёс суртахуун 3. монгол улсын төрийн албаны зарчим, үнэт зүйл 4. төрийн албан хаагчийн харилцаа, хандлага 5. ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ: төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага
Бэрхшээл:
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүдээр цахим сан үүсгэн төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулан мэдээллээр хангах, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд сургалт нөлөөллийн ажлуудыг байнга, давтамжтай зохион байгуулах 2 сургагч багш бэлтгэгдсэн ба тус 2 албан хаагчийн сургалт нөлөөллийн ажлаа хийж гүйцэтгэхэд аймгийн хэмжээний бүх төрийн байгууллагад хүрч ажиллах хүртээмжийн асуудал тулгарч байна.
Санал:
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүдээр цахим сан үүсгэн төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулан мэдээллээр хангах, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд сургалт нөлөөллийн ажлуудыг байнга, давтамжтай зохион байгуулах 2 сургагч багш бэлтгэгдсэн ба тус 2 албан хаагчийн сургалт нөлөөллийн ажлаа хийж гүйцэтгэхэд ажлын цагийн боломж гаргах мөн урамшууллын хөшүүргийг бүрдүүлж ажиллах талаар Ёс зүйн хорооноос томилох эрх бүхий албан тушаалтанд тодорхой үүрэг чиглэл хүргүүлэх.

Шалгах хэсэг:
- "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх. Тийм
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх. Тийм
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх. Тийм

БАТАЛГААЖУУЛАЛТ:
Томилох эрх бүхий албан тушаалтан:
Өвөрхангай аймгийн Засаг даргын
Тамгын газрын дарга: (Ц.ГАНБОЛД)

Ёс зүйн дэд хорооны дарга:
Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын
Ёс зүйн дэд хорооны дарга,
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга: (А.ОТГОНЦЭЦЭГ)

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга:
Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын
Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга, Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Х.МӨНХЦЭЦЭГ)

2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

ATA11169 8448906
9023111371

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлагдсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0	0
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0,5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0,5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0,5	5
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0,5	5
Хэсгийн оноо				4	3	30
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(зарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	1
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	1
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	1
Хэсгийн оноо				3	3	3
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	1
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	1	1
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	1
Хэсгийн оноо				3	3	3
Үнэлгээний нийт оноо, хувь				10	9	90.0

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:
[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".
[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн батлагдсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.
[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.
[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3. мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол.
[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.
[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.
[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.
[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

БАТЛАВ:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Л.А.ОТГОНЦЭЦЭГ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.02.01

Арвайхээр

№	Зорилт арга хэмжээ	Хугацаа	Хариуцан зохион байгуулах албан тушаалтнууд	Хүлээгдэж буй үр дүн
Нэг. Удирдлага, зохион байгуулалт, урьдчилан сэргийлэх чиглэлээр				
1.1	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хүрээнд дэд хорооны гишүүдэд мэдээлэл тухай бүр өгч ажил үүргийн хуваарийг хийх	6, 12 дугаар сард	Дэд хорооны дарга	Хорооны үйл ажиллагаа жигдэрсэн байна.
1.2	Хорооны хуралдааныг улирал тутам зохион байгуулах	3, 6, 9, 12 дугаар сард	Дэд хорооны дарга	
1.3	Байгууллагын нийт албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагын талаарх судалгаа хууль, хяналтын байгууллагаас авч, дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах	4 дүгээр сард	Дэд хорооны нарийн бичгийн дарга	Үр дүнд суурилсан хяналт, үнэлгээ хийгдсэн байна.
1.4	Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хүрээнд шинэчлэн батлагдсан дүрэм журмыг сурталчлах чиглэлээр байгууллагын албан хаагчдад үе шаттайгаар сургалт, арга хэмжээг зохион байгуулах	4, 6, 9 дүгээр сард	Дэд хороо	Шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийг бүх төрийн албан хаагчид судлан танилцаж, мөрдлөг болгож, хэвшсэн байна.

1.5	Байгууллагын албан хаагчдад удирдлагын ёс зүйн, байгууллагын соёл, үйлчилгээний ажилтны харилцааны ур чадвар сэдвээр лекц, ганцаарчилсан уулзалт, яриа таниулга мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах	5 дугаар сард	Дэд хорооны гишүүд	Хамт олны уур амьсгал, хэвшил зан үйл, харилцааны хэв маяг, үүссэн таагүй хандлагыг даван туулах чадвар, үйлчлүүлэгчтэй албан хаагчдын сайн харилцааг бий болгох чадамж нэмэгдсэн байна.
1.6	Албан хаагчдын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолт, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолт, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахих, хэрэгжилтийг хангуулах талаар заалт тусган, үнэлэх	3, 6 дугаар сард	Дэд хорооны дарга, НБДарга	Байгууллагын хэрэгжүүлж, мөрдөж буй баримт бичгүүдэд албан хаагчдын ёс зүйн манлайллын чиглэлээр заалт, арга хэмжээ тусгагдсан байна.
1.7	Байгууллагын албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, байгууллагын үйлчилгээний талаарх иргэд, хэрэглэгчээс санал авах ажлыг хэрэглэгчийн үнэлгээний асуулгад тусган хэрэгжүүлэх	10 дугаар сард	Дэд хорооны гишүүд	Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа өмнөх жилээс сайжирсан байна.
1.8	Харьяа байгууллагуудын ёс зйн дэд хороодыг чадавхжуулах болон “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг бие даан гүйцэтгэх сургагч багш нарыг сургалтад хамруулж бэлтгэх	2 дугаар улиралд	Дэд хорооны гишүүд	“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” -ийн хэрэгжилт бүрэн хангагдаж, ёс зүйн гомдол, саналын тоо буурсан байна.
-	**Хоёр. Гомдол, мэдээлэлд хяналт, шалгалт хийх үндсэн чиг үүргийн хүрээнд**			
2.1	Байгууллагын хэмжээнд ирүүлсэн ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, хүсэлтийг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч бүртгэх, хуваарилах, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг тогтмолжуулах	Жилдээ	Дэд хороо	Холбогдох хууль, тогтоомжийн дагуу үнэн зөв, шударга дүгнэлт гаргаж, саналыг эрх бүхий албан тушаалтанд тухай бүр хүргүүлж цаашид үйл ажиллагаа тогтмолжсон байна.
2.2	Ёс зүйн дэд хорооны тайлан мэдээг хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлж, байгууллагын жилийн эцсийн тайлангийн хуралд танилцуулж, удирдлагуудад санал дүгнэлт хүргүүлэх	6, 12 дугаар сард	Дэд хороо	Байгууллагын албан хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбоотой дүн мэдээлэлд шинжилгээ хийж, дүнгийн мөрөөр ёс зүйн зөрчил арилсан байна.

2.3	Ёс зүйн зөрчлийн мэдээллийг судалсан, дүгнэлт, тогтоол, хурлын тэмдэглэл бусад материалыг архив албан хэрэг хөтлөлтийн стандарт хангаж архивт шилжүүлэх	Жилдээ	Дэд хороо	Ёс зүйн дэд хорооны албан хэрэг хөтлөлт холбогдох дүрэм журмын хүрээнд хөтлөгдөж хэвшсэн байна.
2.4	Байгууллагын жил үйл ажиллагааны тайлан, албан хаагчдын ажлыг дүгнэхэд ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчийг хамт олны саналыг үндэслэн шалгаруулж, урамшуулах саналыг байгууллагын даргад танилцуулах	12 дугаар сард	Дэд хороо	Албан хаагчдын ёс зүйн манлайлал нэмэгдэж, сахилга хариуцлага дээшилсэн байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО